



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар Б/02

Чингис хот

Б.Хүрэлзүрхийг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Агентлаг, нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баатарын Хүрэлзүрхийг 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ч.Баярцолмон Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд: Т.Бямбадулам Архив, бичиг хэргийн эрхлэгч
Т.Баяртуяа Нярав

3. Б.Хүрэлзүрхийн цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 791532 /долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

4. Агентлаг, нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Хүрэлзүрхэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030003